

## **АЖЛЫН ДААЛГАВАР**

/ЧИГЛЭЛ-011/

Ажлын байрны нөхцлийн түүвэр судалгаа хийх

### **ҮНДЭСЛЭЛ:**

Монгол Улсад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр тогтмол хийгддэг, улсын хэмжээний суурь судалгаа үгүйлэгдэж байна. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, нас баралтанд хүргэсэн болон, хүнд ослыг тэглэх нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлогын гол зорилт байдаг. Сүүлийн 20 гаруй жилийн статистик мэдээллээс үзвэл жилд 400 орчим үйлдвэрлэлийн осол, хурц хордлого бүртгэгдэж байна. Гэвч зөвхөн осол, гэмтэл, өвчлөлийн статистик мэдээлэлд тулгуурлан бодлого, арга хэмжээг төлөвлөх нь учир дутагдалтай байна.

Ажлын байрны нөхцлийн түүвэр судалгааг явуулснаар ажилтан ажил үүргээ гүйцэтгэхэд аюулгүй байдал, эрүүл ахуйн хүрээнд учирч байгаа эрсдэл, үүнээс хамгийн өндөр эрсдэлтэй байгаа хүчин зүйлийг тодорхойлох, ажилтан болон эрсдэлт хүчин зүйлийн хоорондын хамаарлыг гаргаж ирэх, тухайн эрсдэлийг арилгахад чиглэсэн бодлого, арга хэмжээг төлөвлөх, цаашдын судалгаа, шинжилгээ хийх үндсэн эх сурвалж болно. Түүнчлэн нотолгоонд суурилсан бодлого боловсруулахад энэхүү судалгаа, мэдээлэл өндөр ач холбогдолтой юм.

Энэхүү түүвэр судалгааг 3-5 жилийн хугацааны давтамжтай, тогтмол хийх зорилготой байна. Судалгааг тогтмол хугацааны давтамжтай явуулснаар ажлын байрны орчин, нөхцөлд гарч буй өөрчлөлтийг харах, харьцуулах, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулахад мэдээллийн гол бааз суурь болохоос гадна ажилтан болон ажлын талаар иж бүрэн зураглалтай болох юм.

### **ЗОРИЛГО:**

Энэхүү судалгааны ажлын үндсэн зорилго нь Монгол Улс дахь ажлын байрны нөхцөл ямар байгааг гарган ирэх, тухайн нөхцөл ажилтанд болон ажил үүрэгт нь хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлоход оршино. Ажлын байрны орчин, нөхцөл болон ажлын байранд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлийн талаар илүү тодорхой ойлголт, мэдээлэлтэй болоход энэхүү судалгаа ач холбогдолтой.

### **СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЦУГЛУУЛАХ МЭДЭЭЛЭЛ:**

Ажлын байрны нөхцлийн судалгааг хийхдээ энэ чиглэлээр олон улсад мөрдөж буй нийтлэг тодорхойлолт, арга зүйд суурилна. Ингэснээр энэхүү судалгааг олон улсын түвшинд бусад улс орнуудад хийгдсэн судалгаатай харьцуулах, тухайн улс орнуудаас авч хэрэгжүүлж байгаа бодлого арга хэмжээ, сайн туршлагаас судалгаа, мэдээлэлд тулгуурлан суралцах, харьцуулах боломжтой болох юм. Ажлын байрны нөхцлийн судалгааны асуулга боловсруулахдаа:

- Еврофонд (Eurofound)-с Европын улсуудад явуулсан ажлын байрны нөхцлийн нийт 6 удаагийн судалгааны асуулга,
- БНСУ-д явуулсан 3 удаагийн судалгааны асуулга,
- Их Британийн Ажиллах хүчний судалгааны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой асуулга, аргачлал зэргийг судалж, өөрийн орны онцлог, ажлын байрны нөхцөл, хөдөлмөрийн харилцааны зохицуулалт,
- үндэсний хэмжээнд хийгддэг Цалин хөлсний бүтцийн судалгаа, Ажиллах хүчний судалгаа зэргийн асуулгатай харьцуулан, уялдуулахад анхаарна.

Асуулгаар гаргах мэдээлэл нь бусад статистик мэдээлэлтэй харьцуулах, дүн шинжилгээ хийх боломжтой, Монгол Улсад мөрдөж буй албан ёсны статистик ангилалтай нийцсэн байх шаардлагатай. Асуулгыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр мэргэшсэн судлаач, мэргэжилтнүүдийг оролцуулан санал авна. Асуулга нөхөх зааврыг хамтад нь боловсруулах бөгөөд туршилтын судалгаа явуулсны үндсэн дээр улсын хэмжээнд зохион байгуулна. Асуулгын дагуу үр дүнг тооцох, дүн шинжилгээ хийх программ хангамжийг бэлтгэсэн байна.

Асуулгаар цуглуулах мэдээлэл:

1. Ажилтны мэдээлэл
2. Хөдөлмөр эрхлэлтийн статус
3. Ажлын цаг, үргэлжлэх хугацаа
4. Ажлын байрны орчин, нөхцөл (дуу шуугиан, чичиргээ, тоосжилт, эргономик г.м)
5. Биеийн болон сэтгэл зүйн эрсдэлт хүчин зүйл
6. Эрүүл мэнд, аюулгүй байдал
7. Ажлын шинж (суугаа, давтамжтай, зөөх зөөвөрлөх, ачих буулгах ажил г.м)
8. Ажлын хурд, ачаалал
9. Байгууллагын дэмжлэг (хариу үйлдэл, шагнал, урамшуулал г.м)
10. Сургалт, мэдээлэл
11. Ялгаварлан гадуурхалт зэрэг.

Судалгааны нэгж нь ажил, хөдөлмөр эрхэлж байгаа нийт ажиллагсад байна. Түүврийн дизайныг гаргахдаа ажлын байрны онцлог, ажил мэргэжил, салбарын ангилал, албан ба албан бус эдийн засагт ажиллагчид зэрэг үзүүлэлтийг харгалзана.

### **ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:**

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас нь зөвлөх үйлчилгээ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад санал авна. Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэгч нь хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар ажлын туршлагатай, эдгээр чиглэлээр түүвэр судалгаа хийж байсан туршлагатай байх шаардлагатай.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ХХБХЗГ-аас судалгааны арга зүй, асуулга боловсруулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, салбарын холбогдох байгууллагуудад судалгаатай холбогдох мэдээлэл, тоот хүргүүлэх, зөвлөх үйлчилгээ гүйцэтгэгчийг холбож өгөх; зөвлөх үйлчилгээний явцад хяналт тавих; зөвлөх үйлчилгээний тендерт шалгарсан баг нь судалгааны арга зүйд тулгуурлан боловсруулсан асуулгаар мэдээлэл цуглуулах мэдээлэл цуглуулагч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээллийг нэгтгэх, мэдээллийн сан бүрдүүлэх, судалгааны тайлангийн төсөлд санал авч эдгээр үйл ажиллагааны явцын болон үр дүнгийн тайлан бичнэ.

#### **ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА:**

- 2019 оны 12 дугаар сарын 10-ны дотор бүрэн хийж гүйцэтгэсэн байна.